



MNAS AC10

МОНГОЛ УЛСЫН
ИТГЭМЖЛЭЛИЙН
ТОГТОЛЦОО

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭЛИЙН ШАЛГУУР

Нэгдсэн үндэсний гудамж 5/1, 3Г-ын II байр
Улаанбаатар 15160, Монгол Улс
Утас: (976) 77073689

Цахим хуудас: www.mnas.gov.mn
Цахим шуудан: info@mnas.gov.mn

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

ХЭВЛЭСЭН ОГНОО:
18.12.2015

ӨӨРЧЛӨЛТ NO: 03
ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО: 25.04.2024

0 Оршил

Аж үйлдвэрийн салбар, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор Монгол Улсын засгийн газар болон Үндэсний итгэмжлэлийн төв хамтарч Чанарын менежментийн тогтолцоо (ЧМТ), Байгаль орчны менежментийн тогтолцоо (БОМТ) болон бусад менежментийн тогтолцооны баталгаажуулалтын итгэмжлэлийн тогтолцоог бий болгохоор ажиллаж байгаа билээ.

MNAS-ийн баталсан Байгаль орчны менежментийн тогтолцооны эхний шалгууруудыг Монгол Улсад явагдаж буй баталгаажуулалтын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, гадаад улс болон бүс нутаг, олон улсын гэрээнд нэгдэх зорилгоор ISO/IEC 17021 стандартын дагуу боловсруулсан. Итгэмжлэлийн шалгуурыг IAF/APAC-аас шинээр хэвлэгдсэн стандарт, заавал дагаж мөрдөх баримт бичгийн лавлагааг тусгах зорилгоор тогтмол шинэчилдэг.

1 Хамрах хүрээ

Энэхүү баримт бичиг нь Байгаль орчны менежментийн тогтолцоо (БОМТ)-ны баталгаажуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хөндлөнгийн байгууллагыг MNAS-аас Байгаль орчны менежментийн тогтолцооны баталгаажуулалтын үйл ажиллагааг явуулах чадвартай, найдвартай гэж үнэлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлно.

2 Шалгуур

- Чанарын менежментийн тогтолцооны баталгаажуулалт хийх итгэмжлэл хүссэн Баталгаажуулалтын байгууллага нь ISO/IEC 17021 “Тохирлын үнэлгээ. Менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалт хийх байгууллагад тавих шаардлага” стандартад заасан шаардлагуудыг хангах үүрэгтэй.
- ISO/IEC 17021 стандартын хувь, хуулбарыг Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)-аас авч болно.

Тайлбар: ISO/IEC 17021 стандартад өөрчлөлт орох бүрт MNAS нь IAF-аас тогтоосон шилжилтийн бодлогыг баримталдаг.

3 ISO/IEC 17021 стандартын шаардлагын удирдамж

MNAS нь ISO/IEC 17021 стандартын шаардлага болон IAF-н заавал мөрдөх баримт бичгүүдийг нэмэлт шалгуурын баримт бичгээр ашигладаг. Итгэмжлэлийн шалгуурын талаар тодруулга хэрэгтэй бол MNAS нэмэлт тайлбар өгнө.

Тайлбар: IAF-н заавал мөрдөх баримт бичгийг IAF цахим хуудаснаас англи, MNAS цахим хуудаснаас монгол хэлээр тус тус үнэгүй татаж авах боломжтой.

4 Итгэмжлэлийн хүрээ

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC10	Байгаль орчны менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 18.12.2015	Өөрчлөлт No:03	Хуудас: 1/3
	Өөрчлөлтийн огноо: 25.04.2024	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

MNAS нь ЧМТ-ны итгэмжлэлийн хүрээг IAF-ын мэдээллийн баримт бичиг (IAF ID 1)-т заасан “Эдийн засгийн үйл ажиллагааны статистикийн нэршил”-д үндэслэн тогтоосон болно.

5 Баталгаажуулалтын байгууллага (ББ)-ын чадамж

MNAS-ийн итгэмжлэл нь тухайн баталгаажуулалтын байгууллага техникийн тодорхой хүрээнд ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцооны баталгаажуулалтыг хийх чадвартайг харуулна. Баталгаажуулалтын байгууллага нь итгэмжлүүлэх техникийн хүрээгээ тодорхойлж, тухайн хүрээнд баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулах чадвартайгаа батлах үүрэгтэй.

Баталгаажуулалтын байгууллага нь итгэмжлүүлэхийг хүссэн техникийн хүрээ, үйл ажиллагаандаа шаардлагатай ур чадвар, чадавхийг ISO/IEC 17021 шалгуур баримт бичгийн дагуу тодорхойлно.

Баталгаажуулалтын байгууллага нь аудитор, шинжээчдийнхээ анхдагч үнэлгээ, ур чадвар, гүйцэтгэл, мониторингийн талаар ISO/IEC 17021 болон ISO 19011 стандартад үндэслэсэн журамтай байна. Баталгаажуулалтын байгууллага нь техникийн тодорхой хүрээнд аудитор / шинжээч бэлтгэх журамтай байна.

Тайлбар: Баталгаажуулалтын байгууллага нь ISO/IEC 17021-2 стандартын А хавсралтад заасан аудиторууд, шинжээчид болон шийдвэр гаргагчдын ур чадварыг харуулна.

6 Баталгаажуулалтын байгууллагын Аудит хийх хугацаа

Баталгаажуулалтын байгууллага нь анхдагч баталгаажуулалт, магадлах хяналт, давтан баталгаажуулалт хийхэд шаардлагатай аудитын хүн өдрийг тодорхойлох журамтай байна. Уг журамд олон салбартай байгууллагад (multisite organisations) аудит хийх хугацааг тооцоолох, баталгаажуулалтыг шилжүүлэх тухай заалтуудыг оруулна.

Баталгаажуулалтын байгууллага нь ISO 14001 стандартын аудитыг хийхдээ шаардлагатай буюу IAF-ийн заавал мөрдөх баримт бичиг, тухайлбал IAF MD 5 зэрэгт заасан дундаж хүн өдрийг ашиглана.

---XXX---

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC10	Байгаль орчны менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 18.12.2015	Өөрчлөлт No:03	Хуудас: 2/3
	Өөрчлөлтийн огноо: 25.04.2024	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

Өөрчлөлтийн бүртгэл

<u>Өөрчлөлт No.</u>	<u>Огноо</u>	<u>Баталсан</u>	<u>Гарсан өөрчлөлт</u>
01	2021.01.20	MNAS дарга	MNAS-д өөрчлөлт гарсан тул жижиг өөрчлөлтүүд хийв.
02	2022.11.17	MNAS дарга	IAF-ын шаардлагад нийцүүлэв.
03	2024.04.25	MNAS дарга	Дахин хянаж, MNAS-д гарсан өөрчлөлтийн дагуу шинээр батлав.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC10	Байгаль орчны менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 18.12.2015	Өөрчлөлт No:03	Хуудас: 3/3
	Өөрчлөлтийн огноо: 25.04.2024	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ